



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2025 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

┌ Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай ┐

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Мал эмнэлгийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 22,000,000.00 (хорин хоёр сая) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашины ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоож, хавсралтад заасны дагуу Завхан аймгийн Мал эмнэлгийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа, Завхан аймгийн Мал эмнэлгийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Чимэддорж нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашиныг автотээврийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132000035

1-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 01 дугаар сарын 09-ны өдрийн
15 дугаар тогтоолын хавсралт

МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТЫН ХУГАЦАА, ҮНИЙГ
ШИНЭЧЛЭН ТОГТООЖ, БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр, марк, улсын дугаар	Арлын дугаар	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ, Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоосон хугацаа (жилээр)	Шинэчлэн тогтоосон нийт үнэ (төгрөг)	Хүлээн авах байгууллагын нэр
1	Тээврийн хэрэгсэл (Ниссан Патрол-У61 маркийн 96-52 УНО улсын дугаартай)	JNITCSY61Z0 581307	2024.05.01	22,000,000.00	3	12,000,000.00	Завхан аймгийн Мал эмнэлгийн газар
	Нийт дүн			22,000,000.00 (хорин хоёр сая)		12,000,000.00 (арван хоёр сая)	